



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 6/125

Хэрлэн сум

**Б.Оюунтуяад мөнгөн
урамшуулал олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолын хавсралт “Төрийн архивын ажилтанд мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.1, 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Архивын тасгийн Архивын тоо бүртгэл, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Базаргүрийн Оюунтуяа нь архивчаар 10 жил 1 сар ажилласан тул сүүлийн 12 сарын хугацааны үндсэн цалингийн дунджийг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр мөнгөн урамшуулал олгосугай.

2.Мөнгөн урамшуулалд зарцуулагдах төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн мөнгөн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА